



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20<sup>18</sup> он  
сарын 05 өдөр

Дугаар ЗГ-1/  
181

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг тус тус үндэслэн Батжаргалын Батзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

УХУРЭЛСҮХ



000197



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

2018 оны 11 сарын 01 өдөр

Дугаар E/29

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Зөвшилцөх саналын тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Батжаргалын Батзоригийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн Таны 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн ЗГ-1/179 дугаартай албан бичгийг хүлээн авч холбогдох материалын танилцаа.

Уг асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА

0000000228

## ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын гишүүнийг  
чөлөөлөх саналын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ ... Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлж болно.” гэж, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Ерөнхий сайд “Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцуулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасан.

Батжаргалын Батзориг нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах жижиг, дунд үйлдвэрийн сантай холбоотой асуудлаар хариуцлага хүлээж, Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө ажуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад албан ёсоор гаргасан тул түүнийг Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1</sup>.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Батжаргалыг Батзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
- 2.Энэ тогтоолыг 2018 оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг